19 сумдын малын тоо толгойн албан татварын 2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн тухай

Аймгийн Засаг даргаар батлуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан 29/04 дүгээр удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн 19 сумдын малын тоо толгойн албан татварын 2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийхэд:

Төлөвлөлт: 2023 онд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэн батлагдаж мөрдөж ажиллажээ. Сангийн журмын 2.8-д “Энэ журмын 2.5, 2.6 болон 2.7-д заасан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална.”, 2.9-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт орсон өөрчлөлтийг орон нутгийн төсвийн тодотголын төсөлд тусган “Төсвийн тухай” хуульд заасны дагуу боловсруулж батлуулна” гэсэн заалтын дагуу сумдын ИТХурлууд 2022 оны 12 дугаар сард “Сумын 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг аймгийн хэмжээнд 3,351,505,500 (гурван тэрбум гурван зуун тавин нэгэн сая таван зуун таван мянга таван зуу) төгрөгөөр баталсан.

Татварын хэмжээ тогтоолт: Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд Албан татварын хэмжээг тогтоох заалтуудын дагуу сумдууд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар албан татварын хэмжээг тогтоож байна. Ингэхдээ сумдууд малын толгой тус бүрд татвар ногдуулж байгаа бол Уянга сум жил бүрийн малтай өрх бүрээс тэмээ 5 толгой, адуу 5 толгой, үхэр 15 толгой, хонь 60 толгой, ямаа 20 толгой малыг албан татвараас чөлөөлөхөөр тогтоосон. Татварыг дунджаар тэмээнд 200-100 төгрөг, адуунд 500-1500 төгрөг, үхэрт 300-1000 төгрөг, хонинд 300-1000 төгрөг, ямаанд 500-1500 төгрөгийн хооронд тогтоожээ. Мөн Монгол улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн коронавирст халдварт цар тахлаас шалтгаалан эдийн засгийн хүндрэлийг даван туулах, малчдын амьжиргааг дэмжих зорилгоор 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл татварыг 0 төгрөг байхаар тогтоосны дагуу сум бүр анх батлагдсан татварын хэмжээг 50 хувийн хөнгөлөлтөөр, Тарагт сум ганцаараа 100% болгон хөнгөлсөн, 2023 онд татварын хэмжээг Баян-Өндөр, Гучин-Ус, Хайрхандулаан, Нарийнтээл гэсэн 4 сум урд жилийн татвараас бууруулан баталсан бусад сумдууд өөрчлөлт оруулаагүй, 2024 онд Бүрд, Баягол, Зүүнбаян-Улаан гэсэн 3 сум урд жилийн татвараас бууруулан тогтоосон, сумын 100 жилийн ойтой холбоотой Баян-Өндөр, Төгрөг, Богд сумдууд 2024 оны татварын орлогыг 0 төгрөг байхаар тогтоожээ.

№	Сумдын нэр	2021 он					2022 он					2023 он					2024 он				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1	Арвайхээр	400	750	400	250	750	800	1500	800	500	1500	Өөрчлөлтгүй									
2	Баян-Өндөр	150	500	250	250	500	300	1000	500	500	1000	150	500	250	250	500	Тэглэсэн				
3	Бүрд	500	500	250	250	500	1000	1000	500	500	1000	Өөрчлөлтгүй					500	500	250	250	500
4	Бат-Өлзий	0	500	400	250	750	0	1000	800	500	1500	Өөрчлөлтгүй									
5	Баруунбаян-Улаан	150	250	150	250	400	300	500	300	500	800	Өөрчлөлтгүй									
6	Баянгол	250	500	400	400	500	500	1000	800	800	800	Өөрчлөлтгүй					400	600	400	600	600
7	Гучин-Ус	300	500	300	400	500	600	1000	600	800	1000	200	600	400	600	600	Өөрчлөлтгүй				
8	Есөнзүйл	250	500	250	250	500	500	1000	500	500	1000	Өөрчлөлтгүй									
9	Өлзийт	0	250	200	150	250	0	500	400	300	500	Өөрчлөлтгүй									
10	Зүүнбаян-Улаан	250	650	250	400	600	500	1000	800	800	1000						0	500	500	400	400
11	Хайрхандулаан	300	500	300	300	600	600	1000	600	600	1200	500	800	500	500	800	Өөрчлөлтгүй				
12	Нарийнтээл	250	500	400	400	750	500	1000	800	800	1500	0	800	800	800	1000	Өөрчлөлтгүй				
13	Сант	125	400	250	250	400	250	800	500	500	800	Өөрчлөлтгүй									
14	Тараг	Тэглэсэн					0	400	250	300	550	Өөрчлөлтгүй									
15	Төгрөг	100	250	200	250	500	200	500	400	500	1000	Өөрчлөлтгүй					Тэглэсэн				
16	Уянга		500	500	500	1000	0	1000	1000	1000	2000	Өөрчлөлтгүй					0	1000	1000	1000	1000
17	Богд	250	400	400	250	400	500	800	800	500	800	Өөрчлөлтгүй					Тэглэсэн				
18	Хужирт	0	500	300	300	600	0	1000	600	600	1200	Өөрчлөлтгүй									
19	Хархорин	250	500	250	400	750	500	1000	500	800	1500	Өөрчлөлтгүй									

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.3-т “сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”, 8.5.4-т “сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах” гэж заасны дагуу төсвийн төслөө өргөн барихдаа малын тоо толгойн албан татварын орлогын тооцооллыг урд оны гүйцэтгэлд үндэслэн багцаагаар хийдэг. Учир нь энэ үед тухайн жилийн мал тооллогын ажил дөнгөж эхлэж байдаг, малын тоо 12 дугаар сарын 25-аас хойш статистик дээр эцэслэн нэгтгэгддэг зэргээс үүдэлтэй байна. Татварын ногдол нь татварын систем дээр бөөн дүнгээр нэхэмжлэх үүсдэг, гүйцэтгэл нь мөн бөөн дүнгээр гардаг, төсөв батлахдаа урд оны авлагаас хэдийг цуглуулах, шинээр үүссэн ногдолоос хэдэн төгрөг төлөгдөхийг задалдаггүй, санхүүгийн тайланд мөн орлогын гүйцэтгэл бөөн дүнгээр тусдаг, гүйцэтгэлийг он тус бүрийн ногдолоос төлөгдсөн байдлаар ялган гаргадаггүй зэргээс үүдэн он тус бүрийн гүйцэтгэл хэдэн хувьтай биелэгдсэн, төлөвлөлт бодитой хийгдсэн эсэхэд дүгнэлт хийх боломжгүй, сумдын татварын байцаагч нарт энэ тухай тооцоолол байхгүй байдалтай байна.

Иймд татварын орлого төлөвлөлт болон гүйцэтгэлд анализ хийхийн тулд Үндэсний статистикийн хорооны цахим хуудаснаас сумдын малын тооны 2020-2022 оны судалгааг авч, сумдын ИТХ-аас баталсан татварын хэмжээгээр сум тус бүрээр татварын ногдуулалтыг гараар тооцоолол хийж, төлөгдсөн татварыг дансны хуулгатай тулган баталгаажуулж 2021-2023 оны өссөн дүнгээр харьцуулалт хийж үзлээ. Ингэхэд 3 жилийн өссөн дүнгээр нийт 8,124,730,425 (найман тэрбум нэг зуун хорин дөрвөн сая долоон зуун гучин мянга дөрвөн зуун хорин тав) төгрөгийн татвар төлөгдөх ёстойгоос 3,906,972,000 (гурван тэрбум есөн зуун зургаан сая есөн зуун далан хоёр мянга) төгрөгийн татварыг төлүүлэхээр төлөвлөж 4,682,621,629 (дөрвөн тэрбум зургаан зуун наян хоёр сая зургаан зуун хорин нэгэн мянга зургаан зуун хорин ес) төгрөгийн татварыг төлүүлсэн буюу дунджаар төлөгдөх татварын 48%-ийг төлүүлэхээр төлөвлөж, аймгийн

хэмжээнд төлөгдөх ёстой татвараас дунджаар 57,6%, сумдууд 41%-72%-ийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс аймгийн хэмжээнд дунджаар 119,9%, сумдууд 0-292,4%-ийн гүйцэтгэлтэй байна.

№	Сум нэр	2021-2023 онд төвлөрөх орлого буюу ногдуулсан татвар	2022-2023 онд төлөвлөсөн орлогын дүн	Төлөвлөлтийн хувь	2021-2023 онд орсон орлогын дүн	Ногдуулсан татвараас тооцсон орлогын	Төлөвлөлтөөс тооцсон орлогын биелэлт
1	Хайрхандулаан	447,287,400	260,700,000	58%	323,137,420	72.20%	123.90%
2	Хархорин	745,522,400	240,000,000	32%	527,987,678	70.80%	220.00%
3	Сант	375,128,825	100,000,000	27%	264,181,444	70.40%	264.20%
4	Төгрөг	305,856,000	163,391,400	53%	215,190,860	70.40%	131.70%
5	Баруунбаян-Улаан	191,531,700	133,982,700	70%	125,363,727	65.50%	93.60%
6	Өлзийт	169,667,600	96,000,000	57%	108,990,768	64.20%	113.50%
7	Тарагт	178,887,550	164,041,000	92%	107,361,115	60.00%	65.40%
8	Есөнзүйл	289,176,000	296,611,600	103%	173,171,930	59.90%	58.40%
9	Бат-Өлзий	577,040,950	329,394,500	57%	337,715,450	58.50%	102.50%
10	Арвайхээр	561,014,250	170,070,000	30%	327,928,698	58.50%	192.80%
11	Уянга	546,814,000	-	0%	311,775,210	57.00%	-
12	Нарийнтээл	444,284,900	312,674,000	70%	244,803,132	55.10%	78.30%
13	Зүүнбаян-Улаан	478,714,950	89,056,000	19%	260,422,515	54.40%	292.40%
14	Баянгол	701,277,400	397,619,800	57%	380,020,963	54.20%	95.60%
15	Богд	452,066,550	288,604,900	64%	237,486,785	52.50%	82.30%
16	Гучин-Ус	245,245,900	175,000,000	71%	121,904,700	49.70%	69.70%
17	Баян-Өндөр	408,176,900	237,548,500	58%	188,097,905	46.10%	79.20%
18	Хужирт	501,318,400	150,000,000	30%	218,077,549	43.50%	145.40%
19	Бүрд	505,718,750	302,277,600	60%	209,003,780	41.30%	69.10%
Нийт дүн		**8,124,730,425**	**3,906,972,000**	**48%**	**4,682,621,629**	**57.60%**	**119.90%**

3 жилийн өссөн дүнгээр хамгийн өндөр орлого төвлөрүүлсэн Хайрхандулаан, Хархорин, Сант, Төгрөг зэрэг сумдууд төлөгдөх ёстой татвараас 70%-иас дээш орлого төвлөрүүлж ажилласан байна.

Малын тоо толгойн албан татварын орлого төвлөрөлт жилийн аль саруудад хэрхэн төлөгдөж байгаад анализ хийх зорилгоор 2022, 2023 оны дансны хуулгад боловсруулалт хийж үзэхэд аймгийн хэмжээнд дунджаар цагаан сарын үе буюу 1 дүгээр сард 2-6 хувь, ноолуур, ноос гарсан үе буюу 5-7 дугаар сард 6-10 хувь, өвлийн идэш хоолны үе буюу 10-11 дүгээр сард 6-20 хувь, хамгийн өндөр төлөлттэй нь жилийн эцсийн мал тооллого буюу 12 дугаар сард 36-40 хувь нь төвлөрч байна. Татвар төлөлтийн дийлэнх хувь 12 дугаар сард орж байгаа нь жилийн эцсийн малын тооллогын ажлаар айл өрх бүрт хүрч татвар төлөлтийг төлүүлдэгтэй холбоотой байна.

2022, 2023 оны малын тоо толгойн албан татвар төлөлтийн судалгааг сараар харуулав.



2023 оны малын тоо толгойн албан татвар төлөлтийн судалгааг сумдаар харуулав.



Малын тоо толгойн албан татварын орлого бүрдүүлэлт хангалтгүй байгаа шалтгаан:

- Сүүлийн жилүүдэд ган, зуд болж, отор нүүдэл ихтэй, ган зудны улмаас хорогдол үүссэн, зудтай байсны улмаас малчид малын өвс тэжээл бэлтгэхэд хөрөнгө мөнгө их зарцуулсан.

- Нарийнтээл, Хайрхандулаан сумдууд 6 сараас 1 жил гаруй хугацаанд татварын байцаагчийн орон тоо эзэнгүй байсан.

- Отроор явсан малчид оторлож байгаа орон нутагтаа албан бусаар татвар төлсөн гэх шалтгаанаар үндсэн газартаа татвар төлөхөөс татгалздаг. Тухайлбал Арвайхээр сумын 36 (ам тоо) малчин өрх, Баян-Өндөр сумын 41 малчин өрх өөр аймагт отроор яваад эргэж ирээгүй.

- Арвайхээр сумын тухайд бэлчээр байхгүй малчид нь бүгд өөр аймаг сумдын нутагт байдаг.

- Зуд болж цас их орсны улмаас малын хорогдол үүсэж тухайн өрхийн малын тоо буурсан учраас малчид хорогдсон малд татвар төлөхөөс татгалздаг.

- Малын тоо толгойн албан татвар төлөлтийн орлогыг сумын нэгдсэн орлого болгон баталдаггүй, зөвхөн хэрэгжүүлэх арга хэмжээндээ тааруулан эх үүсвэр байдлаар баталж байгаагаас төлөвлөгөөгөөр тавих шат дараалсан хяналт сул, татварын байцаагч нарын ажлын үзүүлэлтэд нөлөөлөхгүй учир уг орлогыг оруулах талаар зарим сумдын байцаагч нар идэвх санаачлагатай ажилладаггүй.

- Малчид малын хөлийн татвар төлөх зуршил суугаагүй, хойрго ханддаг.

Малын тоо толгойн албан татварыг төлүүлэхээр сумаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- Сумдууд жилийн эцсийн мал тооллогын ажлын хэсгүүдэд ногдлыг гарган өрх бүрд хүргүүлж, татвар цуглуулах ажлыг зохион байгуулдаг.

- Сумдууд өндөр татвар төлөлттэй иргэдээс эхлэн харьцах дансыг хааж битүүмжлэх ажлыг эхлүүлж байгаа.

- Багийн иргэдийн нийтийн хурлаар дамжуулан татвар төлөхийг уриалах уриалга болон албан мэдэгдэл хүргэн ажилладаг.

- Сумдын татварын байцаагч сар бүр малчид, иргэдтэй утсаар холбогдож татвар төлөхийг анхааруулж, шаарддаг.

- Сумдын ажлын хэсэг багийн айл өрхүүдээр тойрч нэг бүрчлэн мэдээлэл хүргэн, татвар төлөлтийг танилцуулдаг.

- Хархорин сум багуудад малын тоо толгойн албан татвар төлөлтийг цахимаар болон пос машин ашиглан татвар хэрхэн төлөх талаар сургалт зохион байгуулсан.

- Төгрөг сум малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт, малтай өрхийн төлөх татварын ногдол хэмжээ болон албан татварыг онлайн болон бусад хэлбэрээр хэрхэн төлөх зааврын хамт гарын авлага бэлтгэн хэвлэж өрх бүрт хүргүүлэн ажилласан.

- Хайрхандулаан сум малын татвараа 3 жилээрээ нь төлсөн өрхийн малыг үнэгүй угаасан, ЗДТГазрын ажлын хэсэг гарч 3 удаа бүх айл өрхөөр тойролт хийсэн, 2-3 оны малын албан татвар төлөөгүй өрхийн дансанд барилт хийсэн, мал бүхий иргэдэд уриалга гарган хүргүүлж иргэд албан татвараа 100% төвлөрүүлсэн.

Малын тоо толгойн албан татварын орлогын зарцуулалт, зориулалтын дагуу эсэх:

Сумдын ИТХурлууд 2022 оны 12 дугаар сард “Сумын 2023 оны төсөв батлах тухай” тогтоолоор малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг аймгийн хэмжээнд 3,351,505,500 (гурван тэрбум гурван зуун тавин нэгэн сая таван зуун таван мянга таван зуу) төгрөгөөр батлаж, 35,493,800 (гучин таван сая дөрвөн зуун ерэн гурван мянга найман зуу) төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.

2023 онд малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжих нийт 163 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 116 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 47 төсөл арга хэмжээ нь орлого бүрдүүлэлтээс шатгаалан хийгдээгүй үлдсэн нь татварын ихэнх орлого 12 дугаар сард төвлөрч байгаатай холбоотой хэрэгжээгүй байна.

2023 онд малын тоо толгойн албан татварын орлогын санхүүжилтээр 117 төсөл арга хэмжээг 1,952,921,001 (нэг тэрбум есөн зуун тавин хоёр сая есөн зуун хорин нэгэн мянга нэг) төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Баянгол сум нь 2023 онд малын тоо толгойн албан татварын орлогоос 20,000,000 (хорин сая) төгрөгийг “Сумын малын тоо тоолгойн албан татварын орлогоос Эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлан, урьдчилан тооцох боломжгүй гэнэтийн зардалд зарцуулах зорилгоор тус журмыг боловсруулан 11,390,140 (арван нэгэн сая гурван зуун ерэн мянга нэг зуун дөч) төгрөгийг шүлхий болон мялзан өвчнийг арилгах, устгах зорилгоор вакцинжуулах эмч ажилчдын хөлс, шатахуун, постны хоол хүнс, материалын зардалд, өвс тээвэрлэх тээврийн хөлсөнд зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6-д “ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн 4.5 дахь хэсэгт заасан хөрөнгө

оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул сан үүссэн байдлыг таслан зогсоож, үүсгэсэн санг татан буулгах улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүллээ.

Сумдууд төсөв батлах тогтоолд малын тоо толгойн албан татварын орлогоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтаас ялган харуулж баталдаггүй, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх тухайн үед орлого төвлөрөлт дутуу байснаас орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс шилжүүлэн зарцуулдаг, түүнийгээ буцаан залруулга хийгээгүй зэргээс үүдэн дансны хуулгаар гарсан дүн нь хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд зарцуулсан мөнгөн дүнгээс илүү, дутуу харагдаж байна.

Тухайлбал малын тоо толгойн зарцуулалтыг сангийн яамны и-хуулгатай даруулж үзэхэд **Баруунбаян-Улаан сум** 37,430,000 (гучин долоон сая дөрвөн зуун гучин мянга) төгрөгөөр, **Гучин-Ус сум** 38,589,000 (гучин найман сая таван зуун наян есөн мянга) төгрөгөөр, **Зүүнбаян-Улаан сум** 14,500,000 (арван дөрвөн сая таван зуун мянга) төгрөг, **Тарагт сум** 50,934,650 (тавин сая есөн зуун гучин дөрвөн мянга зургаан зуун тавь) төгрөг, **Төгрөг сум** 36,000,000 (гучин зургаан сая) төгрөгөөр тус тус залруулга хийгдээгүй буюу малын тоо толгойн албан татвараар хэрэгжих төсөл арга хэмжээнд ОНХСангийн хөрөнгөөс шилжүүлэн зарцуулсан.

Харин **Уянга сум** 217,600 (хоёр зуун арван долоон мянга зургаан зуу) төгрөгөөр, **Хархорин сум** 14,909,022 (арван дөрвөн сая есөн зуун есөн мянга хорин хоёр) төгрөгийг илүү буюу ОНХСангийн төсөл арга хэмжээнд шилжүүлэн зарцуулсаныг тухайн сумдаас зөв гаргасан гүйцэтгэлийн мэдээллийг ирүүлэхийг шаардсан боловч ирүүлээгүй учир зөрүүг и-хуулгатай даруулж гаргах гэсэн боловч өөрсдийн өгсөн гүйцэтгэлийн мэдээлэлтэй таарахгүй байгаа тул гүйцэтгэлийг дутуугаар нь гаргалаа.

<u>Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, өр авлага, тооцоо бодолт, санхүүгийн тайлан гаргалт:</u>

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд малын тоо толгойн албан татварын орлого, зарлагыг бүрэн тусгаж өгчээ. Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжих төсөл арга хэмжээний 2023 оны санхүүгийн баримтыг шалгахад анхан шатны баримтыг бүрдүүлсэн боловч шүлхийн вакцинжуулалт, малчдад зориулсан сургалт зохион байгуулахад гэрээ байгуулаагүй, аж ахуй чанартай бараа материал болох шатахуун, бусад аж ахуйн материалыг бараа материалын тайлангаар бүрэн дамжуулж орлого, зарлагад бүртгэж хэвших хэрэгтэй байна. Энэ сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжүүдийг байгууллагын хөрөнгөнд бүрэн бүртгэсэн байна.

Сумдууд нийтдээ 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад 981,676,694 (есөн зуун наян нэгэн сая зургаан зуун далан зургаан мянга зургаан зуун ерэн дөрөв) төгрөгийн авлагыг дутуу тусгасан.

Тооцооллыг хүснэгтээр харуулав.

№	Сум нэр	2021-2023 онд төвлөрөх орлого буюу ногдуулсан татвар	2021-2023 онд төвлөрсөн орлогын дүн	2023 оны санхүүгийн тайланд тусгах авлага	2023 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй авлага	Санхүүгийн тайланд тусгаагүй авлагын зөрүү
1	Уянга	546,814,000	311,775,210	235,038,790	241,631,900	(6,593,110)
2	Есөнзүйл	289,176,000	173,171,930	116,004,070	115,978,570	25,500
3	Хужирт	501,318,400	218,077,549	283,240,851	281,778,151	1,462,700
4	Нарийнтээл	444,284,900	244,803,132	199,481,768	197,321,550	2,160,218
5	Зүүнбаян-Улаан	478,714,950	260,422,515	218,292,435	213,760,935	4,531,500
6	Төгрөг	305,856,000	215,190,860	90,665,140	84,434,485	6,230,655
7	Бат-Өлзий	577,040,950	337,715,450	239,325,500	232,817,461	6,508,039
8	Өлзийт	169,667,600	108,990,768	60,676,832	51,013,038	9,663,794
9	Тарагт	178,887,550	107,361,115	71,526,435	56,679,885	14,846,550
10	Хайрхандулаан	447,287,400	323,137,420	124,149,980	109,211,900	14,938,080
11	Баруунбаян-Улаан	191,531,700	125,363,727	66,167,973	45,736,450	20,431,523
12	Сант	375,128,825	264,181,444	110,947,381	65,956,800	44,990,581
13	Баян-Өндөр	408,176,900	188,097,905	220,078,995	142,842,500	77,236,495
14	Гучин-Ус	245,245,900	121,904,700	123,341,200	40,533,000	82,808,200
15	Богд	452,066,550	237,486,785	214,579,765	129,546,400	85,033,365
16	Бүрд	505,718,750	209,003,780	296,714,970	200,463,550	96,251,420
17	Баянгол	701,277,400	380,020,963	321,256,437	216,525,527	104,730,910
18	Арвайхээр	561,014,250	327,928,698	233,085,552	34,200,000	198,885,552
19	Хархорин	745,522,400	527,987,678	217,534,722		217,534,722
	Нийт дүн	**8,124,730,425**	**4,682,621,629**	**3,442,108,796**	**2,460,432,102**	**981,676,694**

Ингэж авлага дутуу тусгаж байгаа шалтгаан нь орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг таван төрлөөр ялган гаргадаггүй учраас авлагыг буруу тооцдог, авлагыг ногдолоос бус дутуу төлөвлөсөн орлогоос тооцож санхүүгийн тайланд тусгадагаас үүдэлтэй. Үүнд: сумдууд зуд болж малын хорогдол үүссэн, малчид отор нүүдлээр явсан, тухайн сумаас шилжээгүй боловч өөр аймаг сумын нутагт оршин суудаг, малчид нь тухайн оршин сууж буй газраа албан татвараа төлсөн байдаг гэсэн тайлбар өгч байгаа боловч Төгрөг сумаас бусад сумдын тухайд эдгээр нь баримтаар нотлогдохгүй байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах энэ хуулийн 5.2-т зааснаар тодорхойлсон малын тоо толгой нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшгийн улмаас хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн түүнийг албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна” гэж заасны дагуу хорогдсон малыг бүртгэлжүүлсэн, холбогдох материал бүрдүүлсэн сум байхгүй байна.

<u>Тухайн сангаас хөрөнгө зарцуулах талаар гарсан захирамж, тушаал шийдвэр, гадны харилцагч байгууллага, хүмүүстэй хийсэн гэрээ, түүний хэрэгжилт, үр дүн:</u>

Малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх захирамж гаргахдаа тухайн арга хэмжээний зардал малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжүүлэхийг орон нутгийн хөгжлийн сангаас гэж ерөнхий утгаар гаргаж байгаа нь сан дотроо хөтөлбөр зориулалтаараа холилдож тухайн хөтөлбөр зориулалтын зарцуулалт буруу гарчээ.

Иймд хөрөнгө зарцуулах захирамжийг гаргахдаа малын тоо толгойн албан татварын орлогоос зарцуулахаар тодорхой гаргадаг байх хэрэгтэй. Мөн шууд худалдан авалтаар хийгдэж буй ажлуудын гэрээг харилцагч байгууллагуудтай бүрэн гүйцэт хийж хөрөнгө зарцуулж байхыг анхааруулж байна.

Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал

Малын тоо толгой албан татварын орлогын төлөвлөлтийг хийхдээ нарийн тооцоолол хийдэггүй, багцаа дүнгээр баталдаг, авлагыг нийт малын тоонд ногдсон татварын ногдолоос бус төлөвлөсөн дүнгээс хөөж тооцоолон дутуу тайлагнадаг, татвар төлөлт хангалтгүй байгаа, орон нутгийн хөгжлийн сан болон малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжих зардлын зарцуулалтыг хийхдээ хөтөлбөр зориулалт хольж гүйлгээг хийдэг, түүнийгээ жилийн эцсийн дүнгээр залруулдаггүй, бараа материалын тайланд орлого, зарлагыг бүрэн тусгадаггүй, сумын Засаг даргын захирамж гаргахдаа малын тоо толгойн албан татварын орлогоос санхүүжих гэж тодотгон дурддаггүй, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн хөгжлийн сан болон малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжих төсөл арга хэмжээг ялган баталдаггүй, төлөвлөсөн төсөл арга хэмжээ бүрэн хийгддэггүй, анхан шатны санал хураалтын хүрээнд өрхүүдэд хангалттай саналын хуудсыг хүргүүлээгүй, эрэмбэлсэн саналын тоо иргэдээс ирүүлсэн саналын тооноос зөрүүтэй байгаа зэрэг нь тухайн жилийн малын тооллого хийгдэж дүн нэгтгэгдэж гарахаас өмнө төсөв батлагддаг, төлөвлөгөө, тогтоол батлахдаа боловсруулалт хангалтгүй хийдэг, малын тоо толгойн албан татварын ихэнх нь 12 дугаар сард төлөгддөг, малчид татвараа төлж сураагүй, хойрго ханддаг, зарим сумдууд татварын байцаагчгүй удсан, татварын орлогыг сумын орлогын бүрэлдэхүүнд оруулдаггүй, зөвхөн хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тааруулан орлогоо баталдаг, үүнээс үүдэн гүйцэтгэлд тавих шат дараалсан хяналт байдаггүй, татварын орлого төлөвлөх нэгдсэн аргачлал байхгүй, холбогдох байгууллагуудаас энэ талаар зөвлөгөө чиглэл өгдөггүй, татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг малын 5 төрөл тус бүрээр тооцоолдоггүй зэргээс үүдэлтэй байна.

Иймд цаашид малын тоо толгойн албан татварыг сумын орлогын бүрэлдэхүүнд оруулан баталдаг байх, түүнд холбогдох байгууллагууд шат дараалсан хяналтыг тогтмол хийдэг байх, санхүүгийн тайланд авлагыг малын тоонд татвар ногдуулсан бүрэн дүнгээр тусгадаг байх шаардлагатай гэж үзлээ.

Долоо. Цаашид анхаарах асуудлын талаар

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

2. Тухайн жилийн малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй тооцоо судалгаанд тулгуурлан бодитой хийх;

3. Тухайн арга хэмжээнээс зарцуулалтыг хийхдээ эх үүсвэр бүрэн үүссэн байхаар төлөвлөж татварын байцаагчтай хамтран орлогыг бүрдүүлж ажиллах;

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал авахдаа саналын хуудсыг тэгш хүртээмжтэй байдлаар тарааж, саналын хуудсанд мэдээллийг бүрэн гүйцэд бөглүүлэх;

5. Иргэдээс ирсэн саналын хуудасны боловсруулалтыг бодитойгоор хийж, саналыг эрэмбэлж байх. БИНХ дээр ирүүлсэн иргэдийн саналыг баримтжуулж, хурлын тэмдэглэлд тусгах;

6. Санхүүгийн тайланд авлагыг малын тоонд ногдуулсан татварын ногдлоор бүрэн гүйцэт тусгах. Малын хорогдол үүссэн, болон бусад байдлаар авлагыг бууруулах тохиолдлуудыг малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5.3-т “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах энэ хуулийн 5.2-т зааснаар тодорхойлсон малын тоо толгой нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшгийн улмаас хорогдсон бол нотлох баримтыг үндэслэн түүнийг албан татвар ногдуулах нийт малын тооноос хасна” гэсэн заалт болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэж байх**.**

7. Сумдын Иргэдийн төлөөлөгчдын хурлаар эх үүсвэр болон төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангаас ялган тусад нь батлуулж байх.

8. Малын тоо толгойн албан татварын ногдол 5 төрлөөр ногдуулж байгаа учраас татварын байцаагч гүйцэтгэлийг 5 төрлөөр гаргаж хэвших.

9. Сумдууд хөрөнгө зарцуулах Засаг даргын захирамж гаргахдаа аль ямар зардлаас гаргаж буйг тодорхой зааж өгөх.

10. Сан дотор дэд сан давхар үүсгэхгүй байх.

11. Шууд худалдан авалтын хийгдэж буй зарим арга хэмжээнд гэрээг бүрэн байгуулж, аж ахуйн материал болон шатахууныг орлого, зарлагыг бараа материалын тайланд бүрэн авч тайлагнаж хэвших.